



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ
УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ

ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар А/59, А/57, А/56,
А/90, А/97, А/79

Улаанбаатар хот

Багшийн хөгжлийн чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан "Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн 6 их сургуулийн багшийн хөгжлийг дэмжих, профессор багш нарын тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багшийн хөгжил хариуцсан нэгжийн үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн 6 их сургуулийн багшийн хөгжлийн чиглэлээр хамтран хэрэгжүүлэх ажлуудад багш нарыг жигд оролцуулах, шаардлагатай санхүүжилтийг их сургуулиуд хуваан гаргахыг тухайн асуудал хариуцсан дэд захирал, газар, албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Боловсрол хариуцсан дэд захирал (Г.Батбаатар), Монгол Улсын Боловсролын их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал (Н.Мягмарцоож), Хөдөө аж ахуйн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал (Р.Чанцалдулам), Монгол Улсын их сургуулийн Сургалт, оюутан хариуцсан дэд захирал (Д.Бадмаанямбуу), Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Сургалт,

оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Н.Ганзориг), Соёл, урлагийн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал (Д.Одсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Н.ХҮРЭЛБААТАР




МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ДЭД ПРОФЕССОР О.АЛТАНГОО



МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Б.ОЧИРХУЯГ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.НАМНАН



ХӨДӨӨ АЖ АХУЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.ХЭРҮҮГА



СОЁЛ, УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Э.СОНИНТОГОС



Төрийн өмчийн их сургуулийн захирлуудын
2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
дугаар хамтарсан тушаалын хавсралт

Төрийн өмчийн 6 их сургуулийн хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд
багшийн хөгжлийн чиглэлээр хамтран зохион байгуулах ажлын төлөвлөгөө

№	Ажлын нэр	Хугацаа	Хариуцах сургууль
1	Багшийн тасралтгүй хөгжил сэдэвт вебинар зохион байгуулах	4 дүгээр сар	Монгол улсын боловсролын их сургууль
2	Багш нарын эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор спортын тэмцээн зохион байгуулах	5 дугаар сар	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
3	Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэгч сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	6 дугаар сар	Соёл урлагын их сургууль
4	Багшийн хөгжлийг их сургуулийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц профессор багш нарын бүтээх эрх чөлөө, үйлийг дэмжсэн үйл ажиллагааны цогц систем болгох хөгжүүлэх загвар боловсруулан санал болгох	9 дүгээр сар	Шинжлэх ухааны технологийн их сургууль
5	Багш нарт зориулсан "Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамж, чанарын баталгаажилт" сэдэвт сургалт зохион байгуулах	10 дүгээр сар	Хөдөө аж ахуйн их сургууль
6	Багшийн хөгжлийн сургалт (Судалгааны цогц чадамжийг хөгжүүлэх) зохион байгуулах	11 дугаар сар	Монгол улсын их сургууль